



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 224

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 4, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 125,784,000.00 (нэг зуун хорин таван сая долоон зуун наян дөрвөн мянга) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


А.АРИУНБОЛД

0000411

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2019 оны дүгээр сарын 1-ны өдрийн
 2023. дугаар тогтоолын хавсралт

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
 НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, дугаар	Үйлд-сэн/ Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Ниссан Патрол SGL суудлын автомашин 55-30 УБЦ	2000/2006	62,892,000.00	62,892,000.00	0.00	3,000,000.00
2	Ниссан Патрол SGL суудлын автомашин 06-20 УБЗ	2006/2006	62,892,000.00	62,892,000.00	0.00	2,000,000.00
	Нийт дүн		125,784,000.00 (нэг зуун хорин таван сая долоон зуун наян дөрвөн мянга)	125,784,000.00 (нэг зуун хорин таван сая долоон зуун наян дөрвөн мянга)	-	5,000,000.00 (таван сая)